

БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ЦАХИМ УР ЧАДВАР, САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН
БОДЛОГО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ДЭМБЭРЭЛ ОВОГТОЙ СЭЛЭНГИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
ЗОРИЛТ 1. “БҮХ НИЙТИЙН ТООН БИЧИГ ҮСГИЙН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ.”							
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Арга хэмжээ 1.1 Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд баримтлах бодлогын чиглэлийг батлуулах	Батлуулсан баримт бичгийн тоо		1	1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр сүүлийн арван жил суралцаж байгаа суралцагсад, төгсөгчид мэдээлэл, цаашдын чиг хандлагыг тодорхойлох зорилгоор судалгааны асуулгыг боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 03/475 дугаартай албан бичгээр Боловсролын ерөнхий газарт хүргүүлж, иүүлсэн судалгааны өгөгдөлд боловруулалт хийж, үр дүнг нэгтгэн бодлогын баримт бичигт тусгав.	01.02-12.12	70%

					2.Олон улсын чиг хандлагыг тодорхойлох хүрээнд Сингапур, Солонгос, Турк, Хятад, ОХУ зэрэг орнуудыг судлан, боловсруулалт хийж бодлогын баримт бичгийн төсөлд тусгав. 3.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд баримтлах бодлогын чиглэлийн төсөл боловсруулсан. Сайжруулах зорилгоор олон улсын туршлага болон эрэлт нийлүүлэлтийн судалгаа авч үр дүнг төсөлд тусгахаар болов.		
2.	Арга хэмжээ 1.2. Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээний төлөвлөгөөний төсөл боловсруулах	Төсөл боловсруулах		1	“Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээ батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, холбогдох материалыг боловсруулж, Засгийн газрын гишүүд, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, И-Монгол академи зэрэг холбогдох байгууллагуудаас санал авахаар 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/153 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Тус тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр Засгийн газрын гишүүдээс	01.02-06.28	100%

					ирүүлсэн саналыг нэгтгэл, холбогдох материалуудын хамт Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/401 дугаар албан бичгээр хүргүүлсэн. "Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн Засгийн газрын 141 тогтоолоор батлуулсан.		
3.	Арга хэмжээ 1.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах	Төлөвлөгөөний тоо Хүргүүлсэн тайлангийн тоо		1 1	1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбарын орон тооны бус зөвлөлийн 2024 оны 1 дүгээр улиралд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03/777 дугаар албан бичгээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлэв. 3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах	01.02-12.10	100%

			салбарын орон тооны бус зөвлөлийн ээлжит хуралдааныг 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр цахимаар зохион байгуулсан. 4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарын орон тооны бус зөвлөлийн 2024 оны эхний хагас жилийн тайланг бэлтгэн 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 03/1272 дугаартай албан бичгээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлэв. 5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн ээлжит хуралдааныг 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр цахимаар зохион байгуулав. Тус хуралдаанаар оны шилдэг хэвлэл мэдээллийн байгууллагыг шалгаруулж хуралдааны шийдвэр болон протоколын хамт 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 03/877 дугаартай мөн 2024 оны тайланг бэлтгэн боловсруулж 11 дүгээр сарын 22-ны өдрийн 03/970 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	
--	--	--	--	--

4.	Арга хэмжээ 1.4. Жендэрийн салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөний биелэлтийн тайланг хүргүүлэх, 2024 оны төлөвлөгөөг батлуулах	Хүргүүлсэн тайлангийн тоо-1 Батлуулсан төлөвлөгөөний тоо-1		1 1	1.Жендэрийн салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. 2.2023 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг маягтын дагуу боловсруулан ЖҮХ-нд хүргүүлэв. 3.Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж, 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 03/81 дугаартай албан бичгээр Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэв.	01.02-02.15	100%
Зорилт 2. “ ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
5.	Арга хэмжээ 2.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлах	Архивлах баримт бичгийн тоо		2	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын Жендэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны баримт болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн үйл ажиллагааны баримтыг холбогдох журамд заасны дагуу архивлан Архив-бичиг хэргийн мэргэжилтэн Ш.Золбаярт	01.10 - 06.20	100%

					2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хүлээлгэн өгөв.		
6.	Арга хэмжээ 2.2.Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө оруулалтын мэдүүлэг гаргах	Ашиг сонирхлын зөрчлийн маягтын тоо		Тухай бүр	ХАСХОМ-ийг 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор шинэчлэн гаргасан.	01.02-02.15	100%
7.	Арга хэмжээ 2.3.Бодлогын баримт бичгүүдийн биелэлтийг гаргах	Хүргэсэн биелэлтийн тоо		Биелэлтийг гаргаж хүргүүлсэн байна.	1.Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн биелэлтийн нотлох баримтыг Үндэсний аудитын газрын холбогдох албан тушаалтанд цахим шуудангаар (nomin-erdenem@audit.gov.mn) хүргүүлэв. 2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг нэгтгэж боловсруулан, нотлох баримтын хамт Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлэв. 3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний биелэлт, авч хэрэгжүүлж буй ажлын талаарх мэдээллийг боловсруулж, нотлох баримтын хамт Төрийн захиргааны удирдлагын газар, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хүргүүлэв.	01.02-12.12	100%

					4.Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан “Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ” арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг нотлох баримтын хамт нэгтгэн боловсруулан ХЭГ-т 2024 оны 02 дугаар сарын 21-ны өдөр хүргүүлэв. 5.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр гарган газрын даргад хүргүүлэв.		
8.	Арга хэмжээ 2.4.Төрийн жинхэнэ албан хаагчийн төлөвлөгөө боловсруулж, нэгжийн удирдлагаар баталгаажуулах	Батлуулсан баримт бичгийн тоо		1	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан гаргаж Газрын даргаар батлуулав	01.02-12.12	100%
9.	Арга хэмжээ 2.5. Удирдлагаас хуваарилсан албан бичгийг шийдвэрлэх, хариуцсан ажлын чиглэлээр албан бичиг боловсруулж, стандартын дагуу гаргах	Шийдвэрлэсэн албан бичгийн тоо		Тухай бүр	93 Албан бичиг шийдвэрлэсэн байна./ERP/	01.02-12.12	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Үүрэг даалгавар 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл 2023 оны шилдэг хэвлэл мэдээллийн байгууллагыг шалгаруулах	Оны шилдэг хэвлэл мэдээллийн байгууллагыг шалгаруулах	0	Шалгаруулалт ыг зохион байгуулсан байна	1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг хэвлэл, мэдээллийн байгууллагыг шалгаруулж, нэр дэвшсэн байгууллагаас ирүүлсэн 2023 оны тайлан болон хурлын тэмдэглэлийг 2024 оны 01 дүгээр 19-ний өдрийн 03/116 дугаартай албан бичгээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлэв. 2. "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг"-ийг шалгаруулах ёслолын үйл ажиллагаа 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Блю Скэй зочид буудлын Диамонд танхимд зохион байгуулагдсан үйл ажиллагаанд тус яамны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Д.Сэлэнгэ нар оролцов	01.10-01.30	100%

2.	Үүрэг даалгавар 2. Пийпл Ин Нийд ОУТББ, Фаро фаундэйшн ТББ-тай 2023 оны 05 дугаар сарын 29-нд байгуулсан санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлын хүрээнд зохион байгуулалт, уулзалт, хэлэлцүүлэгт оролцох	Уулзалт, хэлэлцүүлэгийн тоо		2	1.Пийпл Ин Нийд ОУТББ, Фаро фаундэйшн ТББ-тай 2023 оны 05 дугаар сарын 29-нд байгуулсан санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлж буй DICE төслийн явц, төслийн хүрээнд хэрэгжүүлэх иргэдийн цахим ур чадварын сургалтын агуулга, судалгааны талаар зөвлөлдөх уулзалтыг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулав. Уулзалтад тус газрын мэргэжилтэн Л.Нармандах, Д.Сэлэнгэ нар оролцож санал солилцов. 3.Пийпл Ин Нийд ОУТББ, Фаро фаундэйшн ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй DICE төслийн явц, төслийн хүрээнд "Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах замаар цахим оролцоог нэмэгдүүлэх нь" төслийн хүрээнд хийгдэж буй Цахим шилжилт, цахим ур чадвар олгох сургалтын үйл ажиллагааны хөтөлбөртэй танилцах уулзалтад оролцож, санал солилцов. Уулзалт 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулагдсан. 4.Фаро фаундэйшн ТББ-с зохион байгуулсан "Иргэний нийгмийн байгууллагыг	01.10-06.10	100%
----	---	-----------------------------	--	---	--	-------------	------

					чадавхжуулах замаар цахим оролцоог нэмэгдүүлэх нь” төслийн зөвлөлдөх уулзалтад оролцож, санал солилцов. Уулзалт 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Пима Имперал зочид буудлын хурлын танхимд зохион байгуулагдсан.		
3.	Үүрэг даалгавар 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөлд санал боловсруулан хүргүүлэх			Санал боловсруулан хүргүүлсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөл мөн дагалдан гарах Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд санал боловсруулан 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/876 дугаартай албан бичгээр Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.	04.10-04.30	100%
4.	Үүрэг даалгавар 4. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын веб хуудас болон аппликейшний хүртээмж”-тэй байдлын талаар ТББ болон Банкны холбоо, Финтекийн холбоо, МПХҮХ-дын төлөөлүүдтэй хамтарсан уулзалт зохион байгуулах	Зохион байгуулсан уулзалтын тоо	0	1	Тус яамны хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбарын орон тооны бүс зөвлөл нь “Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын веб хуудас болон аппликейшний хүртээмж”-тэй байдлын талаар Монголын хараагүйчүүдийн холбоо ТББ, Хараагүй хүмүүсийн инновац хөгжлийн төв ТББ, Тэгш оролцоот ээлтэй нийгэм	04.01-04.05	100%

					ТББ, Монголын харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудын холбоо ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын нэмэх цэнэг холбоо ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон Монголын банкны холбоо, Монголын Финтекийн холбоо, Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбооны төлөөллүүдийг оролцуулан цахим уулзалтыг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулав.		
5.	Үүрэг даалгавар 5. Мэдээллийн цаг арга хэмжээг зохион байгуулах, тайлан мэдээг хүргүүлэх	Арга хэмжээний тоо Тайлангийн тоо		1 1	1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбарын орон тооны бус зөвлөл, "И-Монгол академи" УТУГ, "Мэдээлэл технологийн үндэсний парк" ААТУУГ болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан "Мэдээллийн цаг" арга хэмжээг зохион байгуулав. 2.Тус арга хэмжээний талаарх тайлан мэдээг ирүүлсэн маягтын дагуу боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03/783 дугаар албан бичгээр Хөгжлийн бэрхшээлтэй	01.10 - 12.12	100%

					хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлэв.		
6.	Үүрэг даалгавар 6. Эцэг эхийн зөвлөлөөс “Гэр бүлийн өдөрлөг” зохион байгуулах	Өдөрлөгийн тоо		1	Тус яамны эцэг эхийн зөвлөлөөс “Гэр бүлийн өдөрлөг” арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдөр зохион байгуулав.	01.10-12.10	100%
7.	Үүрэг даалгавар 7. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэлэлцүүлэг зохион байгуулах үйл ажиллагаанд оролцох	Хэлэлцүүлэгт оролцох байгууллагуудад мэдээллийг хүргэсэн байх		Мэдээллийг хүргэсэн байна.	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Төрийн ордны Их танхимд зохион байгуулах үйл ажиллагааны талаар ба харилцаа холбоо, мэдээллийн технологи, финтек болон гарааны бизнес эрхлэгчдийн 300 гаруй төлөөлөл рүү холбогдож мэдээллийг хүргэж оролцоог хангаж ажиллав.	05.10-05.14	100%
8.	Үүрэг даалгавар 8. Төрийн албан хаагчийн хөгжил, хамгааллын тухай хуулийн хэлэлцүүлэгт оролцох	Арга хэмжээний тоо		Тухай бүр	Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төслийн танилцуулга болон төрийн албан хаагчийн хөгжлийг дэмжих талаар санал солилцов. Хэлэлцүүлэг 2024 оны 05 дугаар сарын 21-ны өдөр УА -ын хурлын танхимд зохион байгуулагдсан.	05.21	100%
9.	Үүрэг даалгавар 9. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,	Арга хэмжээний тоо		Тухай бүр	Төрийн цахим үйлчилгээ зохицуулалтын газарт төлөвлөгөөт бус хяналт-	06.13-06.20	100%

	үнэлгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах				шинжилгээ, үнэлгээг 2023 он, 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны холбогдох баримт материалтай танилцан өөрийн хариуцсан чиглэлийг дагуу хяналт шалгалтыг хийж, тайланг ХШҮДАГ-ын мэргэжилтэн М.Мөнхтуул /munkhtuul@mddc.gov.mn/ цахим шуудангаар хүргүүлэв.		
10.	Үүрэг даалгавар 10. Радио, теелевизийн үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан сургалт зохион байгуулах	Арга хэмжээний тоо		1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөл, Харилцаа холбооны зохицуулах хороо, Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн хүртээмжийн асуудал” сэдэвт сургалтыг 2024 он 09 дүгээр сарын 24-ний өдөр Бишрэлт зочид буудлын хурлын танхимд зохион байгуулав.		
11.	Үүрэг даалгавар 11. Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд хэрэгжүүлж буй Ахмад настай иргэдийн цахим ур чадвар олгох төслийн үйл ажиллагаанд оролцох, санал хүргүүлэх, хамтран ажиллах	Арга хэмжээний тоо		Тухай бүр	1.“Ухаалаг засаг-2” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй “Үндэсний цахим элч” хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээнд Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Д.Сэлэнгэ оролцов. Нээлтийн үйл ажиллагаа 2024 оны 09	09.	

					дүгээр сарын 24-ний өдөр Монголын Үндэсний Аж үйлдвэрийн танхимд зохион байгуулагдсан. 2.Ухаалаг-2 төслийн хүрээнд хэрэгжүүлж буй Ахмад настай иргэдийн цахим ур чадвар олгох сургалтын гарын авлагад санал боловсруулан төслийн багийнханд хүргүүлэв. 3.“Ахмад настай иргэдийн цахим цахим ур чадварыг нэмэгдүүлэх” хөтөлбөрт оролцуулах маркетинг, сурталчилгааны цогц стртатеги, төлөвлөгөөний дундын тайлантай танилцаж, төслийн багийнханд цахимаар саналаа хүргүүлэв.		
12.	Үүрэг даалгавар 12. Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулсан хэлэлцүүлэг семинарт оролцох	Арга хэмжээний тоо		Тухай бүр	Үндэсний статистикийн хорооноос “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2023”-ны нэгдсэн үр дүнгийн тархаалтын семинарт Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Д.Сэлэнгэ оролцож, санал солилцов. Тус уулзалт семинар 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Blue sky зочид буудлын Даймонд танхимд зохион байгуулагдав.		

13.	Үүрэг 13. Албан ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд санал хүргүүлэх	Санал хүргүүлсэн тоо		Тухай бүр	Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путины 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр Монгол Улсад хийсэн албаны ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд санал боловсруулж 2024 он 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01/349 дугаартай албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлэв.		
-----	--	----------------------	--	-----------	--	--	--

14.	Үүрэг 14. Ажлын даалгавар боловсруулах, үнэлгээний хороо байгуулах ажлын даалгавар	Ажлын даалгавар боловсруулсан тоо		1	1.“Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийх, цаашид баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах” төндэр шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог байгуулах тушаалын төслийг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/55 тушаалаар батлуулав. 2.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийх, цаашид баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах ажлын даалгаварыг боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр ТНБД-аар батлуулав.		
15.	Үүрэг даалгавар 15. Цахим хуудас, аппликейшн хөгжүүлэгч оюутан залууст хөгжлийн талаарх ойлголт хандлага, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх талааар сургалт зохион байгуулах	Арга хэмжээний тоо		Тухай бүр	1.Цахим хуудас, аппликейшн хөгжүүлэгч оюутан залууст хөгжлийн талаарх ойлголт хандлага, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх		

					зорилгоор сургалт зохион байгуулахаар хамтран ажиллахаар 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 03/579 дугаартай албан бичгийг ШУТИС-ын харьяа ХМТС-тай хүргүүлэв. 2.Тус яамны хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөл, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, И-Монгол академи УТҮГ, ШУТИС-ын харьяа Мэдээлэл, холбооны технологийн сургуультай хамтран “Цахим хуудас, аппликейшн хөгжлүүлэгч оюутан залууст зориулсан сургалт”-ыг 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн сургалтын танхимд зохион байгуулав.		
16.	Үүрэг даалгавар 16. Мэргэшсэн болон зөвлөх инженерийн зөвлөлийн хуралдаанд оролцох	Арга хэмжээний тоо		2	1.Мэргэшсэн болон зөвлөх инженерийн салбар зөвлөлийн ажлын хэсгийн хуралдаанд 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Мэдээлэл, холбооны		

					технологийн сургуулийн 101 тоот хуралдав. Хуралдаанаар шинээр элсэн орсон мэргэшсэн, зөвлөх инженерийн сунгалтад хамрагдах суралцагчдын хүсэлт болон холбогдох материалтай танилцан хэлэлцэв. 2.Мэргэшсэн болон зөвлөх инженерийн шалгалтын комиссын нарийн бичгийн даргаар 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдөр МХТС-ийн дээр ажиллав. 3.Харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарын мэргэжилтэнд Мэргэшлийн зэрэг олгох бүрэлдэхүүнийг шинэчлэн боловсруулж, батлуулав.		
17.	Үүрэг даалгавар 17. “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний төлөвлөгөөг СЯ, БШУЯ, ХНХЯ, ЦХХХЯ сайдын хамтарсан тушаалаар батлах, хэрэгжилтийг хангах	Тайлангийн тоо		1	Соёлын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Цахим хөгжил, харилцаа холбооны сайд нарын хамтарсан 2023 оны А/152, А/195, А/57,А/40 дугаар тушаалаар “Бүх нийтийн соёлын боловсрол” арга		

					хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 03/869 дугаартай албан бичгээр Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яаманд хүргүүлэв.		
--	--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан ажлын чиглэлээр байгууллагаас болон бусад газраас зохион байгуулсан хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох	Хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт хамрагдсан байна		Холбогдох хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцсон байна	1.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтад тогтмол хамрагдсан. 2.Удирдлагын академи, БНСУ-н Эдийн засаг, хүмүүнлэг, шинжлэх ухааны үндэсний судалгааны хүрээлэнгийн дэргэдэх Төрийн захиргааны институт (KIPA)-ийн хооронд хамтрын ажилаагааны хүрээнд зохион байгуулагдсан “БНСУ-Монгол хамтын ажиллагаа”, “Төлөвлөлтөөс үнэлгээ хүртэл”, БНСУ-ын зохицуулалтын инновац сэдэвт хэлэлцүүлэг,	01.10-12.12	100%

					семинарт оролцов. Хэлэлцүүлэг, семинар 2024 оны 02 дугаар сарын 21-ны өдөр Удирдлагын академи дээр зохион байгуулагдсан 3.Ухаалаг Засаг- 2 төслийн хүрээнд хэрэгжүүлж буй Ахмад настай иргэдийн дижитал ур чадварыг нэмэгдүүлэх төслийн ажлын эхний уулзалт, хуралд оролцов. 4.Авлигатай тэмцэх газраас “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах” цахим сургалтад хамрагдсан.		
--	--	--	--	--	--	--	--

2.	Арга хэмжээ 2. Цаг үеийн асуудлаар гарсан нэмэлт ажил, үүрэг хэрэгжүүлэх	Нэмэлт ажил, үүрэг хэрэгжүүлсэн байна		Ажлын хэсгийн уулзалтад оролцсон байна.	1.Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан бэлтгэх туршилтын төслийг удирдлагаар хангах ажлын хэсгийн уулзалтад мэргэжилтэн Д.Сэлэнгэ оролцож, санал солилцов. Ажлын хэсгийн уулзалт 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Боловсрол шинжлэх ухааны яамны Соёмбо танхимд болов. 2.Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан бэлтгэх туршилтын төслийн Ажлын хэсгийн 2 дахь хурал 2024 оны 6 дугаар сарын 03-ны өдөр НҮБ-ын Хүүхдийн сангийн их танимд хуралдаж, хурлаар төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлав. 3.Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан бэлтгэх ажлын хэсгийн хуралд оролцож, санал солилцов. Ажлын хэсгийн хуралдаан 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Боловсролын яамны хурлын танхимд хуралдав.	01.10-12.10	100%
3.	Арга хэмжээ 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын тайлан боловсруулахад анхаарах асуудлууд сэдэв сургалтад хамрагдах	Арга хэмжээний тоо		1	Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан "Хөгжлийн бэрхшээлтэй	09.30	100%

					хүмүүсийн эрхий тухай конвенцын тайлан боловсруулахад анхаарах асуудлууд” сэдэвт сургалтад хамрагдаж, санал солилцов. Сургалт Нэгдсэн Үндэсний байгууллагын хурлын танхимд зохион байгуулагдав.		
4.	Арга хэмжээ 4. Тогтвортой хөгжлийн зорилт 4-ийн төлөө хамтдаа бодлогын хэлэлцүүлэгт оролцох	Арга хэмжээний тоо		Тухай бүр	Боловсролын яам, НҮБ-ын хүүхдийн сангаас хамтран зохион байгуулсан “Тогтвортой хөгжлийн зорилт 4-ийн төлөө хамтдаа” аян бодлогын хэлэлцүүлэгт Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Д.Сэлэнгэ оролцов. Хэлэлцүүлэг 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр Туушин зочид буудлын Сүлд танхимд зохион байгуулагдсан.	09.24	100%
5.	Арга хэмжээ 5. Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх “Цахимд зөв байя” 3-р шатны сургалт зохион байгуулах	Арга хэмжээний тоо		Тухай бүр	Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх хүрээнд Кибер аюулгүй байдлын “Цахим зөв байя” 3 дугаар шатны сургалтын үйл ажиллагааг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-тай хамтран зохион байгуулав. Сургалтад 21 аймаг, 9 дүүргийн төрийн албан хаагч, иргэд болон	11	

					хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийт 20000 гаруй иргэд хамрагдав.		
6.	Арга хэмжээ 6. Төрийн байгууллагад мэдээлэл технологийн чиглэлээр ажиллах албан тушаалтны чиг үүрэг, мэргэжил, мэргэшлийн тогтоох чиглэлээр санал боловсруулан хүргүүлэх	Саналын тоо		Тухай бүр	Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хүний нөөцийн бүрдүүлэлт, чиг үүрэг, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүнд хүний нөөцийн аудит хийх багт мэргэжлийн чиглэлээр дэмжлэг үзүүлэх зорилгоор “Төрийн байгууллагад мэдээлэл технологийн чиглэлээр ажиллах албан тушаалтны чиг үүрэг, мэргэжил, мэргэшлийн тогтоох” чиглэлээр санал боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 03/969 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв.	11.10	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Цахим ур чадвар, салбарын хүний нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

Д.Сэлэнгэ /  /
(Нэр, гарын үсэг)

2024 12 06
(Огноо)